

<p>Автотээврийн хэрэгслийн тос тосолгооны материалар хангах, цэнэглэх үйлчилгээ. Ерөнхий шаардлага.</p>	
---	--

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь авто тээврийн хэрэгслийн тос, тосолгооны материал бусад шингэн худалдаалах, цэнэглэх ажил, үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлох ба уг ажил үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь авто тээврийн хэрэгслийн тос, тосолгооны материал, бусад шингэн худалдаалах, цэнэглэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж байгууллага, иргэн болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартыг боловсруулахад ашигласан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ.

-MNS 1-1 : 2006 Монгол улсын хэмжээнд стандарт боловсруулах, хэрэглэх ажлын зохион байгуулалт, түүний үндсэн үйл ажиллагаа, оролцогч талуудын чиг үүрэг, хоорондын харилцааны нийтлэг шаардлагыг журамлан тогтооно.

-MNS 5025 :2010 Авто үйлчилгээ-Ангилал,Ерөнхий шаардлага.

-MNS 4601:2011 Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт .

-MNS 4598:2011 Авто тээврийн хэрэгслийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах шаардлага

-MNS 5342:2007 Авто зогсоол, Ангилал ба ерөнхий шаардлага

-MNS Үйлдвэрлэгчийн техникийн үечилсэн үйлчилгээ хийх шаардлага, олон улсын жишиг бичиг баримтууд

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1 Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

4.2 **Тос тосолгооны материал бусад шингэн:** Тосолгооны материал нь олон төрлийн механизм, суурь машин, төрөл бүрийн хөдөлгүүрийн хөдөлгөөнт эд ангийн хатуу гадаргуугийн хоорондох үрэлтийг багасгаж элэгдлийг бууруулах дулааныг багасгаж хөргөх, зэврэлтээс хамгаалах үрэлтээс бий болсон элэгдлийн жижиг хэсгүүдийг зайлуулах, хөдөлгүүрийн ажиллах бүхий л горимд саад учруулдаггүй уян хатан шинж чанартай бүтээгдэхүүн

4.3 **Аюултай хог хаягдал:** Тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий хүн

амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал юм.

4.4 **Тос, тосолгооны материал бусад шингэн худалдаалах газар:** Авто тээврийн хэрэгсэлд зориулагдсан тос тосолгооны материал, бусад шингэн гэх бараа бүтээгдэхүүнийг жижиглэн болон бөөний үнээр борлуулах цэг.

4.5 **Мэдээллийн сан:** Авто үйлчилгээний байгууллага, иргэдийн хаяг байршил, хүний нөөц, үйлчилгээний онцлог, үйлчилгээний үнэ тариф, ажиллах цагийн хуваарь, үзүүлсэн үйлчилгээний талаархи өгөгдлүүдийг цаашид өргөтгөх боломжтойгоор үүсгэсэн өгөгдөл бааз;

4.6 **Тос, тосолгооны материал бусад шингэн цэнэглэх газар:** Авто тээврийн хэрэгслийг тос, тосолгоо, бусад шингэн зэрэг ашиглалтын материалаар цэнэглэх, цэвэрлэгээ хийх, агрегатын байдал, иж бүрдлийг шалгах, оношлох, чангалах, тослох, тохируулах ажлыг тогтоосон үечлэлийн дотор хийгдэх цогцолбор авто үйлчилгээний газар

5. Автотээврийн хэрэгслийн тос тосолгооны материал, бусад шингэнээр цэнэглэх үйлчилгээнд тавигдах шаардлага.

5.1 Үйлчилгээ үзүүлэхдээ тээврийн хэрэгслийг техникийн шаардлагын дагуу хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тухай бүртгэл хөтлөнө.

5.2 Тээврийн хэрэгсэлд засвар, үйлчилгээ гүйцэтгэх бүрт тухайн тээврийн хэрэгслийн нийт явсан гүйлт, гүйцэтгэсэн ажил, зарцуулсан сэлбэг, хэрэгсэл, тос, тослогоо, бусад шингэн болон ашиглалтын материалын мэдээллийг тухай бүрт мэдээллийн санд тэмдэглэнэ.

5.3 Үйлчилгээний газрын барилга, байгууламжийн төлөвлөлт шийдэл нь үйлчилгээний технологийн урсгалыг хангасан байна.

5.4 Авто үйлчилгээнээс гарсан аюултай хог хаягдлыг зориулалтын бат бөх, урвалд ордоггүй саванд түр хадгалдаг байна.

5.5 Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулсан байна.

5.6 Өргүүр болон сувгийн тоогоор, утаа зайлуулах төхөөрөмжтэй байна.

5.7 Тухайн тээврийн хэрэгслийн суудал эд анги зэргийг бохирдуулах сэвтээхээс хамгаалах бүрээс, уут сав, арчих цэвэрлэх, угаах материал хэрэглэнэ.

5.8 Авто тээврийн хэрэгсэл, түүний эд ангид гагнуур хийх нөхцөлд зориулалтын хангалттай ажиллах агаар бүхий тусгай өрөө, талбайд тухайн ажилбарыг хийж гүйцэтгэнэ

5.9 Үйлчилгээ хийгдэж буй талбайд ил халаагууртай халаах хэрэгсэл, үйлдвэрлэлийн бус хийцийн цахилгаан тоноглол, багаж хэрэгсэл ашиглахгүй байх

- 5.10 Ашиглалтаас гарсан тос тосолгооны материал, хуванцар сав, тосны шүүр зэргийг хадгалах агуулах байгууламжтай байна. Ил галын болон аюулгүй ажиллагааны санамж, тэмдэг тэмдэглэгээг тавина
- 5.11 Хөрсөнд ажилласан тос тосолгоо, бусад шингэн алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан зайлуулж тусгаарлагч гадаргуу дээр овоолон хлорт уусмалаар бороожуулах арга хэмжээг төлөвлөсөн байна.
- 5.12 Ашигласан хаягдал тос, бусад шингэнийг агуулах байгууламж нь шууд нарны тусгал, бороо, үерийн ус хуримтлагдахааргүй байна.
- 5.13 Нэг төрлийн тосыг бусад төрлийн тосруу холихгүй хадгалах
- 5.14 Үйлчилгээ үзүүлсний дараа тосны талаар мэдээлэл бүхий наалтыг наана.
- 5.15 Ажлын байрны бэлтгэл хангах дараалал
- 5.15.1 Ажлын хувцас өмсөх /албан тушаал, овог нэр байх/
- 5.15.2 Ажил хүлээж авах
- 5.15.3 Өдөр тутмын ХАБЭА-н зааварчилгаа авах
- 5.15.4 Зориулалтын хувийн хамгаалах хэргэслийг бэлтгэх
- 5.15.5 Ажлын байрыг зориулалтын ажилд бэлтгэх
- 5.15.6 Багаж тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх

5.16 Тос тосолгоо, бусад шингэн болон ашиглалтын материалаар цэнэглэх үйлчилгээний газарт шаардлагатай багаж хэрэгслийн жагсаалт

Төрөл	Шаардлагатай багаж хэрэгсэл
Туслах багаж хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> • Зөөврийн хайрцаг • Хөргөлтийн шингэн хомут наадаг тууз • Гар чийдэн, анхааруулах тэмдэг • Зэв арилгагч шингэн шүршүүр • Амтай болон гогцоо түлхүүрний цуглуулга • Дорцоов,
Үндсэн багаж хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> • Отверткны цуглуулга • Бахь • Түлхүүр болон дорцоов • Алх болон хасуур • Домкрат
Хэмжих хэрэгслүүд	<ul style="list-style-type: none"> • Тестер болон шалгах, ламп • Цилиндрийн битүүмж шалгах манометр • Тайминг гэрэл • Двел болон тахометр (эргэлтийн хурд хэмжигч)
Бусад	<ul style="list-style-type: none"> • Ган утастай сойз • Хүйтэн гагнуурын алх • Тулгуур • Дугуйн эвүүр • Ажлын хувцас

Тос тосолгооны багаж хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> • Хурдны хайрцагт тос хийх урт хоолойтой юүлүүр • Тос шахах насос • Хөргөлтийн шингэний хөлдөх температур шалгах багаж • Тос юүлэх сав • Өтгөн тосны шахуурга • Тосны уут • Урт хошуу • Уян хошуу • Нарийн хошуу • Богино хошуу • Шүүр авах түлхүүр • Тосны шахуурга • Юүлүүр • Уян гуурстай юүлүүр • Тосны сав • Тосны гүц • Тосны шүүрний дорцоов • Бүтээлэг • Тосны бохирдол шалгагч • Даралт хэмжих манометр • Цэнэглэх толгой буюу хамгаалах клапан
-------------------------------	--

6. Автотээврийн хэрэгслийн тос тосолгооны материал, бусад шингэн, ашиглалтын материал худалдахад тавигдах шаардлага.

- 6.1 Үйлчилгээний талбай нь авто тээврийн хэрэгсэл саадгүйгээр орж гарах боломжийг хангасан байна.
- 6.2 Тос тосолгоо, бусад шингэн болон ашиглалтын материал нь нийлүүлэгчийн мэдэгдэл, тохирлын гэрчилгээтэй байна.
- 6.4 Үйлчилгээний мэдээллийг цахим сүлжээнд оруулсан байх. Бүтээгдэхүүний нэр төрөл зориулалт, үйлчилгээний талаар мэдээллийн лавлахтай байна.
- 6.5 Ажилласан хаягдал тос, бусад шингэнийг агуулах байгууламж нь бороо, үерийн ус хуримтлагдахааргүй байна.
- 6.6 Автомашины тос тосолгооны материалаар цэнэглэх үйлчилгээ эрхлэгчдийн нь технологийн картад заасан ажилбаруудыг зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ.
- 6.7 Суурин ба зөөврийн тоноглол нэг бүрд техник ашиглалтын бүртгэлийн дэвтэр хөтөлж, аюулгүй ажиллагааны заавартай байна.
- 6.8 Цахилгаан болон гар багажууд, сервисийн тоног төхөөрөмжүүдийг ашиглахын өмнө заавал хэвийн ажиллаж буй эсэхийг шалгаж ашиглана. Ил харагдах механик гэмтэл, цахилгаан хэлхээний гэмтэл, түгжигч болон унтраалганы хэвийн ажиллагааг заавал шалгасны дараа ашиглах

- 6.9 Авто үйлчилгээний байгууллага нь тухайн ажил үйлчилгээний технологийн картад тусгагдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон байна.
- 6.10 Автомашины сэлбэг, хэрэгсэл, тосолгооны болон ашиглалтын бусад материалын борлуулалтын ажилтан нь автотээврийн мэргэжлийн сургалтын болон авто үйлчилгээний төрөлжсөн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан, борлуулж буй сэлбэг, хэрэгслийн талаар бүрэн мэдлэгтэй, үйлчлүүлэгчид мэргэжлийн зөвлөгөө өгөх чадвартай байна.
- 6.11 Засвар, үйлчилгээний засварчин нь автотээврийн мэргэжлийн сургалтын болон авто үйлчилгээний төрөлжсөн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан, засвар, үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн эзэмшсэн, засварын технологи ажиллагаа, технологийн картыг судалж мэдсэн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникт суралцаж дадлагажсан байна.